



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН
ХОЛБООНД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2020.04.23 № 3/1671
танай _____-ны № _____-т

Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай

Хорооны 2018 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 165 дугаар тогтоолоор, Хорооны 2018 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт загвар”-т Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 166 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлсэн.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2-т тус тус заасны дагуу дээрх нэмэлт, өөрчлөлтүүд нь 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд танай холбоо нь гишүүн даатгалын компаниудын хамт тус тогтоолуудын хэрэгжилтийг хангаж, мөрдөж ажиллахыг үүгээр мэдэгдье.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 3947, 3948 дугаарт тус тус бүртгэгдсэн Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 165, 166 дугаар тогтоолуудын хуулбарыг хавсаргав.

Хавсралт: ... хуудас.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

151800000487



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 04 сарын 08-ны
өдөр хүлээн авсан.

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг
тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн “ашиглах” гэснийг “хэрэглэх” гэж, 2.3.1 дэх заалтын “1 /нэг/ жилийн” гэснийг “365 хоногийн” гэж, мөн хэсгийн “1 жилийн хугацаанд” гэснийг “365 хоногт” гэж, 2.3.5 дахь заалтын “1 жилийн” гэснийг “365 хоногийн” гэж, 2.3.7 дахь заалтын “1 жилийн” гэснийг “365 хоногийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Журмын 2 дугаар зүйлийн 2.4.4 дэх заалтыг хассугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 04 сарын 17-ны
өдөр хүлээн авсан.

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын
мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар"-т
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт, загвар”-г дор дурдсан агуулгатай 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг нэмсүгэй.

1/ “6.4. Даатгагч нь энэ гэрээний 6.2-г заасан хураамжийн буцаан олголтыг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний мэдүүлгийн маягтад бөглөсний дагуу ажлын 5 хоногийн дотор олгоно.”

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 212 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт”-ын 4 дүгээр зүйлийн “Мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалыг хийлгэх үү: Тийм/Үгүй” гэсний дараа “Даатгалын гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, хураамжийн буцаалт хийх тохиолдолд мөнгө хүлээн авах: Бэлэн мөнгөөр; Дансаар; Хэрэв дансаар хүлээн авах бол: Банкны нэр: ... Дансны дугаар: ... Данс эзэмшигчийн овог, нэр: ...” гэж, энэхүү тогтоолын 1-д заасан гэрээний стандарт, загварын 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь хэсгийн “эрх бүхий этгээдээс” гэсний өмнө “шаардлагатай тохиолдолд” гэж тус тус нэмсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1-д заасан гэрээний стандарт, загварын 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “8.2.3” гэснийг “7.2.3” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг “холбогдох” гэж, 2-т заасан маягтын 3 дугаар зүйлийн хүснэгтийн “1 жилийн хугацаанд” гэснийг “365 хоногт” гэж, 4 дүгээр зүйлийн “1 жилийн хугацаанд” гэснийг “365 хоногт” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

